

## Хэвлэл мэдээлэл, коррупци

МЧАСЭ-ийн Ерөнхийлөгч, Коррупцитай тэмцэх Терийн бус байгууллагын Зөвлөхүүдийн танхимын гишүүн **Ц.Дашдондов, 1999 он**

Коррупци гэж ярих нь хвсмээр зүйл биш. Гэвч хвсэхгвй гээд дуугвй сууж болохгвй нь. Учир нь Монголд коррупци ахархан хугацаанд асар хурдан үржин телжиж, газар авч байна.

Коррупцийн тухай асуудал олон талтай агаад тэрхvv талын тоо нь байнга нэмэгдэж байна. Энд би “Хэвлэл мэдээлэл, коррупци” гэсэн сэдвээр ярих болж байна. Тэгэхдээ мэдээж хэвлэл мэдээлэл бол коррупци гэх гээгвй. Тэр хоёр ойлголтыг хооронд нь холбож ойртуулах гээгвй. Тэгж ч болохгвй. Авилга /коррупци/, хэвлэл мэдээлэл хоёр айлсаж зэрэгцэх ёсгвй. Могой, зараа хоёрыг нэг байранд байлгаж болохгвй биз дээ. Яг л тэрvvн шиг юм байгаа юм. Нэг нь байвал нөгөө нь байхгвй л байх учиртай.

Хаана чөлөөт хэвлэл мэдээллийн хөгжил сул дорой байна, тэнд коррупци цэцэглэж, газар авч байна. Хаана коррупци их байна, тэнд хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт хэвлэл хөгжих бололцоо боогдож хумигдана. Нvvрлэх аюул нь ч асар их байх болно. Үvнийг vнэмшилтэй болгохын тулд нэг зүйл нэмж хэлье. Манай гаригийн сэтгvvлчдийн хамгийн том хамтын нийгэмлэг болох Брюсселд төвтэй Олон Улсын Сэтгvvлчдийн Холбооны баримт бичигт: “Хэрвээ сэтгvvлчид коррупци, ядуурал, айдас, болгоомжлолын нөхцөлд байгаа бол тэнд хэвлэлийн эрх чөлөө гэж байхгвй” (There can be no press freedom if journalists exist in conditions of corruption, poverty or fear) гэж заасан байх юм.

Монголд коррупци байна уу гэвэл байна. Байх байхдаа бүр төрийн дээд өндөрлөг УИХ-ын гишvvдээс нэр холбогдохоод байна. Коррупци ингэж өндөр авч байгаа нь манайд хэвлэлийн эрх чөлөө цаашид байх эсэхийг ч их эргэлзээтэй болгож байна. Улмаар энэ нь төрт ёсны нэр хүндэд сөв суулгаж ардчилалын ололтыг бусниулж мэдэхээр байна. Чөлөөт хэвлэлд бичигчдсэнчлэнгээр манай парламентийн зарим ашигт vйлчилсэн нь vнэн л бол хүнд шийтгэл хүлээдэггвй юмаа гэхэд ядаж ёс суртахууны хариуцлага хүлээх учиртай. Төсөрхөн “Дээдсийн хүрээлэн” сонинд нэгэн ахмад туршлагатай өмгөөлөгч ярилцлага өгөхдөө: “Казиногийн хэргийг өмгөөлөгчидтэй vнэхээр санал нийлээгвй. Манай өмгөөлөгч нар мөрдөн байцаах, прокурор нар луу асуултыг чиглvvлсэн байдлаар явсан. Хэрвээ мөрдөн байцаагч нар гомдол гаргах юм бол өмгөөлөгч нь буруудах ёстой” гэсэн байх юм. Казинотой холбогдох хэрэг, явдлыг эрэн сурвалжилж бичсэн сэтгvvлчид энэ бүхнийг хэр зэрэг харгалзан бодолцож, хэр зэрэг жин бантай сэтгэж, сэргэлэн ажиллаж чадсан юм бол доо?

Монголд коррупци ихээхэн өндөр авч, гол төлөв эрх мэдэлтэй, бэл бэнчинтэй хүмvvс холбогдож байгаа нь тvvнтэй хийх тэмцлийг ихээхэн хүндрvvлж, бэрхшээлтэй болгож байна. Сөрөө хайргвй хүн гэж байдаггвй болохоор “би хээл хахууль авсан” гэж хэлэх хүн ч байхгвй байна. Коррупци өөрөө өр бусын гэмээр онцгой vйлдэл учраас vвнтэй тэмцэх арга, хэлбэр ч гэсэн мөн л ялгаагвй өр бусын шинжтэй байх шаардлагатай. Сөрөө хэлбэл, коррупцитай ердийн аргаар тэмцээд төдий л амжилт олохгвй. Сэтгvvлчид коррупцитай ердийн аргаар тэмцээд төдий л амжилт олохгвй. Сэтгvvлчид коррупцитай тэмцэнэ гэхэд

яаж тэмцэх вэ? Энд ердийн сэтгүүл зvйн тvвшинд ажиллаад олигтой амжилт олохгvй. Харин “Investigative journalism” буюу “Эрэн сурвалжлах сэтгүүл зvй”-д ихээхэн ач холбогдол өгч, найдлага тавихаас өөр аргагvй. Гэхдээ эрэн сурвалжилна гэдэг нь хvний ул шагайна, өө хайна гэсэн vг огт биш. Эрэн сурвалжлах сэтгүүл зvй нь ердийн сэтгүүл зvйгээс ямар ялгаатай вэ гэхээр, асуудлын гvнд орж, аливаад олон талаас нь хандаж, нарийн ширийн нягталж, хеделбергvй баримтад, гарцаагvйгээр нь нотлох нь эрэн сурвалжлах сэтгүүл зvйн мөрдөх нэг гол зарчим. Учир битvвлэг явдлын учигны vзвvр, уяаны гогцооноос нэгэнт л гогдоод авсан бол тvүнээ алдчихгvй улам, улам лавшруулсаар эцсийг нь vзэх гэж эцэж цуцашгvй хөөцөлдөж, хэдэн сар жилээр ч хамаагvй уйгагvй тэмцэж ажиллах нь “Investigative reporter” буюу “Эрэн сурвалжлагч”-ийн энгийн сэтгүүлчээс ялгарах онцлог нь юм.

Далд бугшмал вйлдлийг ил гаргаж, нийтийн нvдний өмнө дэлгэж тавих гэхээрээ коррупци мэтийн ээдрээг вйлдлийн эзэн холбогдогчийн эхнэр юм уу нөхөр эсвэл эцэг эх, ах дvв, хамаатан садан, найз нөхдөөр нь хvмvүсийн толгой эргvүлсэн элдэв юм яриулж, нийтэлснийгээ эрэн сурвалжилж байна гэвэл их өрөөсгөл. Яагаад гэвэл, өөрийн талын хvнээ муулаад сууж байдаг тийм усан тэнэг хvн ховор биз ээ. Коррупци гэдэг онцгой шинжтэй, осолтой, хэцvв сэдэв учраас тvүний тухай муу бичиж болохгvй. Энд гарсан бага алдаа ч их vнэ цэнэтэй хор уршиг хойноосоо дагуулах учраас хөнгөн гоомой хандаж бvвч таарахгvй. Мэргэжлийн маш өндөр тvвшинд, этика, өс зvйгээ нарийн чанд сахиж ажиллах шаардлага ердийнхөөс огт ондоо өндөр тvвшинд тавигдана. Коррупцийг илчлэх хэцvв. Хэцvв нь юундаа байна вэ гэхээр авилга авсан, өгсөн хоёрын аль аль нь нууц, далд вйлдэгддэг. Илрvүлж бичихдээ эндэж алдах л юм бол эзэн холбогдогч нь дорхноо дvрвэж далд ороод, арга тактикаа амархан өөрчлөнө.

Коррупцитай тэмцэхэд сэтгүүлчид бид юу хийж чадах, бас юу хийж чадахгvй, яаж ажиллаж болох хийгээд яаж ажиллаж болохгvйг маш сайн мэддэг байх хэрэгтэй юм. Авилга буюу коррупцийн тухай бичиж, мэдээлэхдээ сураг, таамгаар баримт, нотолгоо муутай, аз туршсан байдлаар ажиллах осолтой. Авилга буюу коррупцийн эзэн холбогдогчийг илчилж нийтэд мэдээлэх нь сэтгүүлчид, ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүлчдийн гvйцэтгэвэл зохих vүрэг. Энд “public watch-dog” буюу олон нийтийн соргог мэдрэмж, сонор чих болсон сэтгүүлчид, чөлөөт хэвлэлийн учир холбогдол vнэхээр их vгvйлэгдэж таарна. Илчилж мэдээлэх, эзэн холбогдогчийг тодруулах, коррупцитай тэмцэхийн чухлыг олон нийтэд ойлгуулж, коррупцийг vл тэвчих vзэл, хандлагыг төлөвшvүлэхэд хэвлэл мэдээлэл, ялангуяа бие даасан, хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл vлэмж vүрэгтэй. Тэгэхдээ яллагчийн vүрэг гvйцэтгэх өсгvй. Хуулийн өмнө хэн гэм буруутайг нь тогтоох гээд байх ч явдалгvй. Тухайн вйлдэл гэмт хэргийн шинжтэй эсэхийг ч тодорхойлох гэх хэрэггvй. Яагаад гэхээр сэтгүүлч бол яллагч биш. Коррупцитай тэмцэхэд сэтгүүлчид юу хийж чадах, юу хийж чадахгvй, яаж ажиллаж болох, яаж ажиллаж болохгvйг тухайд товчхондоо иймэрхvв.

Коррупци хаана их бугшиж байгаа, хэн их холбогдож байгаагаас шалтгаалж тvүний хор холбогдол, уршигт vр дагавар янз янз. Хэрвээ төрийн тvшээд, өндөр дээд зэрэглэлийн албан тушаалтан коррупцид холбогдвол vүнээс vүсэх уршигт vр дагавар, нийгэм, хvн ардад учрах хохирол хичнээн ноцтой болох нь хэн бvхэнд илэрхий. Тэрнээс биш тэр ч коррупци, энэ ч коррупци гэх маягаар аар саар зvйлээр хөөцөлдөж, асуудлыг хэт

жигжигрүүлж, хавтгайруулж эзэнгүйдүүлэх нь ноцтой вйлдлээс нийтийн анхаарлыг холдуулж, зальтай этгээдүүдэд завших боломж олгохоос өөр өөртэй зүйл авчрахгүй болох нь ардчилал, шударга ёс хөгжсөн оронд аль хэдийнээ ажиглагдаж мэдрэгдсэн зүйл байх юм. Дэлхийн сэтгүүл зүйн практикаас үзэхэд илчилж, бичиж мэдээлэхдээ онилж, чиглэх объектоо зөв баримжаалж байх хэрэгтэй юм байна. Тэр ч коррупцид холбогдолтой, энэ ч авилгад автагдсан гэх зэргээр зальхай этгээдүүдийн завхуул үгэнд автагдаж, замаасаа хазайж будилмааргүй юм байна. Орчин цагийн ойлголтоор коррупци гэгдэхээр тэрхүү аюулт үзэгдэл тегрег, мөнгө байлаа гэхэд тэр нь сая саяар, тэр ч бүү хэл тэрбумаар тоологдохоос бус эгнээ нэг “мянга юм уу “зуу”” гэж яригдах зүйл огт биш байх нь ээ. Энийг хэн хийж чадах вэ гэвэл ихээхэн эрх мэдэлтнүүд эсвэл асар айхтар арга заль, бэл бэнчинтэнгүүд хийж чадна. Иймээс ч коррупцитай хийх тэмцэл бэрхшээлтэй бөгөөд олон тохиолдолд боломжгүй болж тегсдөг тал ч байна.

Монголд ноцтой коррупци чухам хаана байна, хэн холбогдож байна гэвэл мөн л голдуу эрх мэдэлтнүүдийн дотор, банк, санхүү, зээлийн хүрээнд илүүтэй газар авч, гаарч байгаа нь нууц биш юм. Тэрнээс биш тэр коррупци гэдэг чинь энгийн иргэдийн дунд юм уу эсвэл эгэл малчны хотод байдаг зүйл биш байх нь ээ. Байлаа ч гэсэн тэр нь нийгэмд хохирол учруулж чадахгүй. Ийм болохоор хэвлэл мэдээллийнхэн бид коррупцитай цаашид тэмцэхдээ ихээхэн учир ялгавартай хандаж, ухаалаг ажиллах шаардлагатай болж байна. Түүгээр зогсохгүй маш олон буруу ойлголт, төөрөлдүүлж дэг эвдсэн дэмий үг, далд явууллагыг даван туулах хэрэгтэй болж байна.

Төрийн албан хаагчдын цалин бага байгаа нь коррупцид холбогдох ганц гол шалтгаан гэх нь холгүй ярих явдал байна. Цалин бага байх нь бусдын нөлөөнд автаж, коррупцид ертөх магадлалыг ихэсгэдэг нь үнэний хувьтай боловч тэр нь төрийн түвшнэд коррупцид орооцолдох цорын ганц шалтгаан болж чадахгүй. Хүннээс юм авах сонирхолгүй болтол нь цалинжуулна гэдэг бол бараг боломжгүй зүйл. Цалин нэмэх замаар коррупцийг үгүй болгоно гэвэл үлгэр. Сард сая тегрегний цалинтай байсан ч хүннээс авах хүсэл, сонирхол байхгүй болчихгүй. Монголын хамгийн ядуу, хамгийн цалин багатай нь хээл хахууль, коррупцид холбогдож байна гэвэл энүүн шиг худал юм байхгүй. Харьцангуй өндөр цалинтай, эрх мэдэлтэй хүн коррупцид холбогдсоор байгааг бид юу гэж ойлгох вэ? Төрийн зарим өндөр албан тушаалтан тангарагаасаа няцаж, ёс зүйгээ зерчиж байгаатай холбож үзэх ёстой. Орлогын мэдүүлгээ цагт нь өгөхгүй, өгсөн ч худлаа өгдөг хувийн үлгэр дууриалгүй, үнэнч бус хүн УИХ-ын гишүүдийн дотор ч байна.

Америк зэрэг оронд ямар байна вэ? Төрийн өндөр албан тушаалтан жил бүрийн 5-р сарын 15-нд орлогын мэдүүлэг өгөх ёстой гээд ёс зүйн кодекс, дүрэмд нь заачихсан бол тэрнийг яс баримталж байна. Үнэнч шударга байхыг үгийн төдийд бус үйл ажлаар хэрэгжүүлж чаддаг улс сайхан юм аа.

Ахар богино хугацаанд гайхмаар хурдан бэхжиж, маш сэжигтэйгээр баяжиж байгаа нь анхаарал татахгүй байхын аргагүй болсон хүн УИХ-д байна. Тэд далд бизнес, далд эдийн засаг нууцаар эрхэлж, хээл хахууль, коррупцитай нэр холбогдож, хэвлэл мэдээллийнхний хараанд ертеж байна. Тийнхүү ертеж байгаадаа дургүйцэж биднийг “онцоллоо” хэмээн эсэргүүцэх гэж оролдож байна. Онцлолгүй яах вэ дээ. Нэгэнт олны их итгэл хүлээж сонгогдсон бол яалт ч үгүй. Хараа, хяналтад дургүйцэх байсан юм бол яах гэж сонгогдоно

вэ? Ямар тэднийг дургүй байхад нь, “намайг битгий сонгоорой” гээд байхад нь “таныг заавал сонгоно” гээд албаар сонгочихоогүй. еерсдее л “ингэнэ”, “тэгнэ” гэсэн элдэв амлалт егч, эмгэд евгедед гурил будаа тарааж, гуйж гувшиж байж гарч ирсэн биш бил вv. Үй олны итгэл хвлээж сонгогдсон, внэнч ажиллана гэж тангараг ергесен терийн том эрх мэдэлтнийг энгийн иргэдээс эрс ялгаатай авч вээж, ёс зvйн ендер шаардлага тавьж, хазгай гишгэхийг нь андахгvй байхыг хичээдэг нь хэвлэлийнхний хувьд зев юм. Тэгж баймааж нь “public watch-dog” буюу олон нийтийн сонор чих, соргог манаа байж чадна. Үvнийг би хараат бус, бие даасан, челеет хэвлэл мэдээллийнхэнд хамааруулж хэлж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг тууштай либеральчлаагvй, тэдгээрийг тер засгийн хяналтаас челеелж, биеийг нь даалгаагvй байсан цагт коррупцитай хийх тэмцэл амжилт олно гэсэн баталгаа байхгvй.

Дэлхий дээр хамгийн зусарч телевиз хаан байна гэвэл Монголд байна. Манай тев телевизээр орой вvхэн 5-10 сайд, дарга тогтмол гарч байна. Тев телевизээр гардаг сайд, дарга нарыг харахад “Энэ телевиз чинь бидний юм. Тэгэхээр намагй хэн хэлэхэв” гэсэн байдалтай маадгар байхыг нь яана. Ганцхан телевиз ч биш. Ёмне нь тер засгийн мэдэлд байсан, едгее челеелегдсен нэртэй боловч, нэдэр дээрээ бахь байдгаараа, дарга нарт долигонож, тэдэнд внэнчээр вйлчилсэн хэвээр, удирдлагын ул долоогч, тийм зусарч телевизтэй, ийм бялдууч хэвлэлтэй улс оронд коррупци цэцэглэн дэлгэрэхгvй яах вэ. Телевиз яахаараа дарга, сайд нартай эзтэй сvжрээд байна гэвэл тер зесгийн мэдлийнх учраас тэр. Даргыг нь дээрээс шууд томилдог болохоор тэр.

Үvн дээр нэмж хэлvвштэй нэг зvйл гэвэл сэтгvвлчдээс мэдээллийн эх сурвалжид нэвтрэх боломж хаалттай, олсон эх сурвалжийн нууцыг хадгалж, хэлэхгvй байхыг баталгаажуулсан хууль эрхийн акт алга байна. Ардчилал хөгжсөн, хvний эрхийг хvндэтгэдэг, хэвлэлийн эрх челеег дээдэлдэг, олон эшт вэлийг эрхэмлэдэг Америк зэрэг орны жишгээр FOA (Freedom of information act), Бамбай хууль (Shield Law) мэтийг гаргаж, тэдгээрт уншигч, вээгч, сонсогч тvмний хvвсэн мэдээллийн эх сурвалжид нэвтрэч, хэрэгцээт мэдээ, тоо баримтыг сэтгvвлчид олж авах гэхэд нь аль нэг албан тушаалын зевтгех вндэслэлгvйгээр татгалзах буюу хориг саад тавих ёсгvйг хуульчлан зааж егех хэрэгтэй байна. Үvний тулд заавал тусгай хууль байх албагvй. Тvрvвн нь Э.Бат-Үвл нарын санаачилса Хэвлэл мэдээллийн эрх челеенний тухай хуульд зарим нэг нэмэлт заалт оруулах замаар ч шийдэж болно.

Челеет хэвлэл мэдээлэл хөгжих хууль эрх зvйн таатай орчин бүрдээгvй цагт коррупци, хээл хахууль, албан тушаалтны гэмт хэрэг гэх зэрэг аюулт вээгдэлтэй амжилттай тэмцэх боломжгvй. Би энд коррупци, хээл хахууль хоёрын хамтруулаад хэлчихлээ. Дашрамд егvвлэхэд хээл хахууль бол коррупци биш харин коррупци бол хээл хахууль мөн гэж вэдэг тал бий. Ямартаа ч болов олон тvмний идэвхтэй оролцоо, тэдний зvгээс вэвvлэх хvчтэй дэмжлэггvйгээр сэтгvвлчид дангаараа коррупци, хээл хахуультай тэмцээд олигтой вр дvнд хvрэхгvй. Коррупци гэхэд л еерее их евермец шинжтэй, онцгой хvнд сэдэв учраас тvвний тухай муу бичиж болохгvй. Муу бичих юм уу хариуцлагатай, хайш яайш хандвал дараа нь засч, залруулах аргагvй уршигт вр дагавар вvсгэж мэдэхээр байна. Үvнийг сvвлийн вейн жишээ баримт нотолж байна.

Казиногийн гэсэн тодотголтой хээл хахууль, коррупцийн хэргийг илчилж, таслан шийдвэрлэх явцад нийтийн нүдний өмнө зөвхөн хуульчид, өмгөөлөгчид хэн болохоо харуулж, хүнд шалгалт өгөөд зогсоогүй, сэтгүүлчид бас шалгалт өгсөн. Тэр шалгалтад сэтгүүлчид ямар дүн авсан бэ гэвэл “сайн”, “муу”, “дунд” гэх зэрэг байж болох бараг бүх дүнг тавиулсан. Коррупцийг яаж илрүүлдэг, хэрхэн тогтоодог, юу гэж бичдэг, яаж мэдээлдэг талаар суурь ойлголт, үндсэн мэдлэггүйгээс сэтгүүлчид чиг баримжаа муутай, хамаа хандаж хадуурсан. Аль нэг зальхай этгээдийн арга явуулгад автаж, улс төрийн панз үсэргэгчийн олз болж ийш тийш их савласан. Казиногийн тухай сэтгүүлчдийн нэг хэсэг нь нэг юм хэлж байхад нөгөө хэсэг нь огт ондоо зүйл ярьж байсан. Үүнээс болоод улс төр, иргэний зориг гаргаж ажилласан үед сэтгүүлчдийн эв санааны нэгдэл их үгвйлэгдэж, дутагдаж байв. Нэг юмны тухай өөр өөр бичиж мэдээлээд байхаар хүн ард ихээхэн теерелдеж жинхэнэ үнэн хаана байгаа, юунд байгааг мэдэх боломжгүй болоход хүрч байв. Асуудлыг ингэтлээ их будлиулсан тал бий. Тэгэхдээ сэтгүүлчид дандаа л алдаад байгаагүй. Оносон тохиолдол олон. Казино гэдэг чухам юу болох, коррупци гэдэг ямар хор хохиролтой болох тухай олон нийтэд ойлголт өгч, нүдийг нь нээхийг хэн хийсэн бэ гэвэл хэвлэл мэдээллийнхэн хийсэн. Чөлөөт сэтгүүлч, чөлөөт хэвлэл гэж байгаагүй бол өргөн олон нийт казино, коррупци, хээл хахуулийн талаар өнөөдрийнх шиг ийм их баялаг дэлгэр мэдээлэлтэй байж чадахгүй байх байсан. Чингэхдээ бид ололтоо ярихдаа орхисноо үгвйлэхгүй, амжилтаа дурдахдаа алдсанаа хэлэхгүй байж болохгүй. Казино, түүнтэй холбогдох хэрэг бол хуульчдын хувьд төдийгүй сэтгүүлчдийн хувьд ч урьд өмнө төдий л олон тохиолдож байгаагүй цоо шинэ тулгар сэдэв байсан. Казиногийн хэрэг, коррупцийн талаар яаж бичиж, мэдээлэх ёстойгоос яаж мэдээлэв, юун дээр нь алдаж, юун дээр онов гэдэг талаар эцсийн дүгнэлтийг энд би хийх гээд хэрэггүй. Үүнийг судлаач, шинжээч, шүүмжлэгчид хийх нь илүү зохимжтой. Үүнээс үүдэн өгүүлэхэд манайд сэтгүүл зүйн судлал-шүүмжийг цаашид сайтар хөгжүүлэх шаардлагатай байна.

Монголын сэтгүүл зүйн ертөнцөд феномен гэмээр сонин үзэгдэл, содон үйл явдал, онцгой тохиолдол гарах тоолонд түүнд тухай бүр нь үнэлэлт өгч, үүний юу нь болж, юу нь болохгүй байгаад дүн шинжилгээ хийж, дор дор нь хэлж байх нь манай сэтгүүл зүй эрүүл саруул гольдролоор эрчимтэй хөгжихөд түлхэц болно. Сэтгүүлчид өөр хоорондоо үг хэлээ ололцохгүй, нэгнийхээ бичсэнийг нөгөө нь үгвйгсэж, эв тунжингүй байх нь улс төрийн ашиг хонжоо хайж, нэр алдар олох гэсэн өвжин этгээдүүдийн олз болж ашиглагдах боллоо. Тэр нь юугаар илэрч байна гэвэл нэг үе чөлөөт хэвлэлтэй хонь чоно болж, зарга зальхай болж байсан зарим нэг зальхай этгээд гэв гэнэт зүсээ хувиргаж, чөлөөт сэтгүүлчдэд хайр зарлаж, хэвлэлийн эрх чөлөө гэж юу байдгийг хэлж чадахгүй мөртлөө зөвхөн бусдын амаар будаа идэж, мэдээллийн эх сурвалжид нэвтрэх, мэдээлэл олж авах тухай хууль хүртэл санаачлах ухааны юм ярьж байгааг бид юу гэж ойлгох ёстой вэ! Улс төрийн панз үсэргэгчийн увайгүй зан, шижээргүй авир гэхээс өөрөө ойлгох хэрэггүй болов уу. Хэзээ тэр этгээд хэвлэл мэдээллийнхэнд хайртай болчихвоо гэж бодохоор сэтгэлд нэг л бууж өгөхгүй байгаа юм.

Манай сэтгүүлчид шаардлагатай үе, эгзэгтэй цаг мөчид нэгдэж, нягтарч чадахгүй, энэ талаар өөр туршлагагүй, огт суралцаагүй байгаа нь казиногийн хэрэг явдлын өрнөлт, уг хэргийн шүүн таслах үйл явцын үеэр ажиглагдлаа. Бусад улс оронд бол тийм байдаггүй. Нөхцөл байдал бишдэж хүндрэх тусам, асуудал хурцдах тусам, дайралт, дарамт шахалт ихсэх тусам сэтгүүлчид улам нягтарч, улам эв нэгдэлтэй болж нүүрлэж болзошгүй

ямарваа аюул, гэнэтийн дайралтын еедсэ хамтдаа сөрөн зогсож тэмцэхэд сайтар бэлтгэгдсэн байдаг. Ингэсэн тохиолдолд сэтгүүлч ганцаардаж, хар хүчний өмнө хүчин мөхөсдөх нь бага байдаг. Юуны төлөө, хэний эрх ашгийг хамгаалж байгаагаа сайтар мэдэж, ухаарсан сэтгүүлчид коррупци, хээл хахууль, албан тушаалын гэмт хэрэг, аюулт мафийн эсрэг ёстой хатан зориг гарган тэмцэхдээ амь насаа алдахаас ч айдаггүй. Амь эрсдлээ ч гэсэн ард нь үлдсэн үзэг нэгт нөхөд нь үйлсийг нь үргэлжлүүлдэг. Ийм жишээ олныг дурдаж болно. АНУ-ын нэгэн хотод маш том мафийн үйлдлийг илчилж, дэлгэн тавьсан сэтгүүлчийн амь насыг бүрэлгэсэн явдал гарсан. Тэгэхэд түүнд дургүйцсэн сэтгүүлчид хүчээ нэгтгэж, зоригоо чангалан тэмцэж, мөнөөх мафийн бүлгийг дахин сэхэхгүй болтол нь бут авсан байх юм.

Америкийн сэтгүүл зүйн түүхэнд тэмдэглэж үлдсэн нэгэн баримтыг тэр хэвээр нь сийрүүлбэ. *“Investigative journalists expose wrongdoing. Phoenix, 1976 – A ware of invesgative reporting exposes unsound dams, unsafe cars, corrupt cops and corruptible politicians. In Phoenix, a team of journalists avenges the car-bomb murder of “ARIZONA REPUBLIC” reporter Don Bolles by finishing his probe of political corruption and organized crime. The crusade invigorates investigative reporters and editors, a national group that eventually numbers 3,000 members. ... Journalists often see themselves as watchdogs.”* Сэтгүүлчид иймэрхүү эв санааны нэгдэлтэй байвал хэр баргийн юманд дийлдэхгүй. Эв нэгдэлгүйгээсээ болж ямар ч хохирол амсаж мэднэ. Хэрэгтэй цагт эвлэлдэн нэгдэж чадахгүй, хатуу бэрхийг туулахдаа хамтарч мэдэхгүй, нягтарч сураагүй, зөвхөн л нэг амь амиа хоохойлж, мөр мөрөө хөөх нь бидний сонгох зам биш. Хөгжсөний юм уу хүчтэйн шинж ч биш. Харин сул доройн шинж.

Сэтгүүлчдийн хэн нь хэнтэйгээ муудалцаж, эвдрэлцэх нь гэдгийг ашиглах гэж анаад сууж байдаг хүн байна. Тэр чухам хэн бэ гэдгийг шаардлага гарвал хэлэх болно. Сэтгүүлчдийн дотроос аль гуйвамтгай, аль аймхай хулчгарыг нь түүж авч, талдаа татаж ашиглах гэсэн атгаг санаа агуулж явдаг зарим нэг завхуул этгээд сонгууль дөхсөнөөс болоод ч тэр үү сүүлийн үед сүрхий идэвхжих хандлагатай байна. Тэр ч байтугай нэг “улс төрч” ухаантай өчүүхэн амьтан бусдаас хариугаа авч, өшөө хорслоо тайлах гэхээрээ чөлөөт хэвлэлийг ашиглахыг завдаж буй тийм хачин юм ч саяхнаас анзаарагдах боллоо. Одоогийн ороо бусгаа байдлыг далимдуулж оноо авч, од шүүрэхийг горьлогч завхуул этгээдийг зоргоор нь тавьбал яаж ч баллаж мэдэхээр байна. Тийм болохоор сэтгүүлчдэд улс төрийн өндөр сонор сэрэмж, эв санааны бат нэгдэл хэзээ хэзээнээс илүү их эрхэм чухал болж байна. Коррупци, хээл хахууль гэх мэт нийгмийн сөрөг үзэгдэлтэй тэмцэнэ гэхээрээ бид дээр өгүүлсэнчлэн эерэг, сөрөг их олон олон хүчин зүйлийг хамтад нь харгалзан бодолцож, болж л өгвөл өсгөй сэтгэж, хийгүй гишгэж явмаар байна.